



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/208

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийн дагуу БШУЯ/20240101021/01/01 урилгын дугаартай Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал (Өвөрхангай, Сант сум) ажлыг 2,749,274,085 (хоёр тэрбум долоон зуун дөчин есөн сая хоёр зуун далан дөрөв мянга наян тав) төгрөгөөр Өндөрбөх ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0432